Улаанбаатар хотын ахмад настны эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, үйлдлийг судалсан дүн

Д.Долгорсүрэн[1,2], Д.Мягмарцэрэн[2], З.Хишигсүрэн[2]

[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн тэнхим
[1]АШУҮИС, АУС, Өрхийн Эрүүл Мэндийн тэнхим
[2]АШУҮИС, Дорноговь АУС
Цахим шуудан: dolgorsuren.d@mnums.edu.mn, Утас:99022964

Түлхүүр үг:

Ахмад настан
Хүчирхийлэл
Хэлбэр
Үйлдэл

Товч утга:

Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын 2018 оны мэдээгээр Дэлхий дээр 2015 онд 60 ба түүнээс дээш настай хүн 900 сая байгаа бол 2050 онд 2 тэр бумаар өснө гэж тооцоолсон байна.[1] Хятадын хүн амын дунд ахмад настнуудын хүчирхийлэл түгээмэл буюу 0.2%-64% байдаг болохыг судлаачид тогтоосон байна.[2] Монгол улсад судлаач Р.Оюунханд нар ахмад настны хүчирхийлэлтэй холбоотой байж болохуйц зан төрхийн эмгэг, сэтгэл түгших, сэтгэл гутрах эмгэг хамгийн их байгааг цаашид нарийвчлан судлах шаардлагатай хэмээн дурдсан байна.[3] **Зорилго:** Улаанбаатар хотын ахмад настны эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, үйлдлийг судалсан дүн. **Арга, аргачлал:** Судалгааг нэг агшингийн загвараар, зорилтот түүврийн аргаар судалгааны тоон болон чанарын аргыг хослуулж мэдээ материалаа цуглуулсан. **Үр дүн:** Бидний судалгаанд 55-96 насны нийт 962 ахмад настан хамрагдсаны дундаж нас нь 65.6±7.49 жил, ам бүлийн дундаж тоо 3.33±1.96 байлаа. Хүчирхийлэлд өртсөн ахмад настнууд бие махбодын 161(16.7%), Сэтгэл санааны 295 (30.7%), Бэлгийн 26 (2.7%), Үл хайхрах 255 (26.5%), Эдийн засгийн 268 (27.9%) өртжээ. Үүнээс харахад аль ч хүчирхийллийн үед сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртдөг байна. Бие махбодын хүчирхийлэл үйлдэл нь өшиглөх 72 (10.0%) алагдах 86 (8.6%), цохих 107(6.3%), 22.4% чимхэх 36 (13.5%), түлхэх 80 (9.2%), хазах, эд зүйл шидэх 81 (9.1%), үйлдэл нь статистик ач холбогдолтой байна (p<0.05). Үүнээс зэвсгийн чанартай эд зүйл тодруулахад хутга, мэс 15 (15.4%), мод чулуу 53 (11.9%), бусад шил сандал 29 (14.2%) ашигласан статистик ач холбогдолтой байв (p<0.05). Сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэл нь муу үгээр хараах 215 (22.3%), Загнах 224 (23.3%), буруутгах 160 (16.6%), айлгах 108 (11.2%), хардаж мөрдөх 33 (3.4%), сүрдүүлэх 84 (8.7%), сонирхол харгалзахгүй шийдвэр 67 (7.7%), ганцаардуулах 184 (19.1%), шийтгэнэ асрамжид өгнө гэж сүрдүүлэх 64 (6.7%) үйлдэл нь статистик ач холбогдолтой байна (p=0.000). Үл хайхрах хүчирхийллийн үйлдэл нь 190 (18.9%) гадуурхах, 190 (18.9%) ярихгүй байх,107 (11.3%) хэрэгцээ хангагдахгүй, 173 (18.8%) асаргаа хийгдэхгүй, 55 (5.7%) гэрээс хөөх, 36 (3.7%) эм уулгахгүй, 78 (8.1%) ад шоо үздэг байна (p=0.000). Эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн үйлдэл нь эд хөрөнгө завших 73 (7.6%), мөнгө хулгайлах 110 (11.4%), зээл зөвшөөрөлгүй авхуулах 132 (137%), тэтгэвэр өгөхгүй байх 101(10.5%), өөрийн хэрэгцээнд зарцуулахгүй 174 (18.1%), орон байр зөвшөөрөлгүй зарах 31(3.2%), данснаас мөнгө зөвшөөрөлгүй авах 76 (7.9%), бичиг баримтад гарын үсэг зуруулах 33 (3.4%), ахуйн хэрэгцээ хангагдахгүй байх 67 (7.0%), эрүүл мэндийн хэрэгцээ хангагдахгүй 165171.2%), байх зэрэг хүчирхийлэх үйлдэл нь статистик ач холбогдолтой байлаа (p<0.05). **Дүгнэлт:** Хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзвэл бие махбодын 161 (16.7%), сэтгэл санааны 295 (30.7%), бэлгийн 26 (2.7%), үл хайхрах 255 (26.5%), эдийн засгийн 268 (27.9%) өртөж аль ч хүчирхийллийн үед сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртдөг болох нь тодорхойлогдлоо.

Үндэслэл: Дэлхий дахинаа хүн ам зүйн насны бүтцэд өөрчлөлт явагдаж байгааг судлаачид онцлон тэмдгэлсэн байна. Олон улсын төвшинд хүн ам насжихын хэрээр ахмад настны өвчлөл, хүчирхийлэл өсөн нэмэгдэж хөгжиж буй орнуудад сар бүр 10 ахмад настны 1 нь хүчирхийлэлд өртдөг, 24 ахмад настны 1 нь хүчирхийлэлд өртсөнөө бусдад мэдээлдэг гэжээ.[3] ДЭМБ-ын 2018 оны мэдээллээр Африкийн бүс нутагт


9.4 жилээр тус тус нэмэгдсэн хандлага ажиглагдсан байна. Энэхүү үзүүлэлт нь дэлхийн хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтын өнгөрсөн зууны туршид гарсан үзүүлэлтийн хамгийн сайн өсөлт буюу дундаж түвшинг давсан үзүүлэлттэй байна.[4.5] Судлаач Coren (2008) нар хүчирхийлэл нь 3.2-27,8% тархалттай, биеийн 1.9%, ЭЗ 4.1%, 3.6% үгэн хүчирхийлэл, 2.4% үл хайхрах, 4.2% Сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн байна.[6] Судлаач Ven Den (2019) нар сэтгэл санааны хүчирхийлэл 44.5%, эдийн засгийн 34% бие махбод 19.1%, бэлгийн хүчирхийлэл хамгийн бага 3% эзэлсэн гэжээ.[7] Энэтхэг, Африкийн зарим улсад бэлэвсэрсэн настныг хүчээр дахин гэрлүүлэх эсвэл гэр бүлээс нь хөөдөг 15 бол Хятад улсад жил бүр 500 орчим эмэгтэй настнуудыг шулмын хорлол болсон хэмээн гүтгэж тэдний зарим нэгний амь насыг нь хөнөөсөн байна.[16]

Хэвлэлийн тоймоос үзвэл хүчирхийлэлд өртсөн настнуудын зарим нь өөрийгөө үл хайхрах байдлаар гаргуунд нь орхидог болох нь тогтоогдсон ба энэ нь зарим талаараа сэтгэл гутрах эмгэг болон танин мэдэхүйн бууралт үүссэнтэй холбоотой болохыг 2812 ахмад настныг хамруулсан судалгааны үр дүн нотолжээ.[17] Судлаач Choi (2018) нар сэтгэл санааны хүчирхийлэл хамгийн их буюу 40.1%, бие махбодын 31.3%, эдийн засгийн 7.2%, үл хайхрах 19.1%, бэлгийн 1.3% байгаа болохыг тодорхойлсон байна.[21] ДЭМБ-ын тайлан мэдээнд дурьдсанаар (2019) олон улсад дунджаар нийт эмэгтэйчүүдийн 30.0% нь амьдралдаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг бөгөөд судалгаанд хамрагдсан улс орнуудын дундаж түвшин харилцан адилгүй төдийгүй Папауа, Шинэ Гвинейд 68% (сүүлийн 12 сард 33%), Соломоны арлын улсуудад 64% (сүүлийн 12 сард 44%), Вануату улсад 60% (сүүлийн 12 сард 44%) байсан бол Хятад улсын хувьд 39% нь амьдралынхаа хугацаанд, сүүлийн 12 сард 9%, Монголд амьдралдаа 32%, сүүлийн 12 сард 13% нь тус тус хүчирхийлэлд өртсөн байдаг гэжээ. Судлаач Р.Оюунханд нар "Монгол улсын настнуудын өвчлөлийн тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндийн байдал" судалгаандаа ахмад настны хүчирхийлэлтэй холбоотой байж болохуйц зан төрхийн эмгэг, сэтгэл түгших, сэтгэл гутрах эмгэг хамгийн их байгааг цаашид нарийвчлан судлах шаардлагатай хэмээн дурдсан байдаг.[15.16] Манай улсад Улаанбаатар хотын хэмжээнд хийсэн ахмад настны хүчирхийллийн судалгаа ховор байгаа нь энэхүү судалгааны ажлыг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Улаанбаатар хотын ахмад настны хүчирхийллийн хэлбэрүүд, хүчирхийлэл үйлдлийг судлан тогтоох


Арга, аргачлал: Судалгааг нэг агшингийн загвараар, зорилтот түүврийн аргаар судалгааны тоон болон чанарын аргыг хослуулж мэдээ материалаа цуглуулсан. Түүврийн хэмжээг Улаанбаатар хотын 6 дүүргийн Эрүүл мэндийн төвийн ахмадын төвөөр сүүлийн 3 жилд үйлчлүүлсэн ахмад настны тоог дүүрэг бүрээс авч эх олонлог болгон дараах $n=\frac{N\times P\times(1-P)\times Z^2}{(N-1)\times E^2+Z^2\times P\times(1-P)}=917$ томьёогоор тооцоолж гаргав. Улаанбаатар хотын 6 дүүргийн ахмадын төвүүд, ахмад настны эмнэлэг, өрх, худалдааны төвүүдийг түшиглэн 962 хүн хамруулан Карт 1 ашиглан 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй настныг зорилтот түүврийн аргаар судалгаандаа хамруулсан. SPSS-24.0 программыг ашиглаж статистик боловсруулалт хийж болон олон хүчин зүйлийн регресс тестийг ашигласан, P-утга <0.05 бол статистикийн хувьд ач холбогдолтой гэж үр дүнг тооцсон. АШУҮИС-ийн Судалгааны ажлын ёс зүйн хорооны 2019/3-08 тоот зөвшөөрлийн дагуу хийж гүйцэтгэв.

Үр дүн: Бидний судалгаанд 55-96 насны нийт 962 ахмад настан хамрагдсаны дундаж нас нь 65.6±7.49 жил, ам бүлийн дундаж тоо 3.33±1.96 байлаа. (Зураг 1).




Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын хүчирхийлэлд өртсөнг судалсан дүн.

Бид хүчирхийлэлд өртсөн ахмад настнуудыг ямар хэлбэрийн хүчирхийлэлд илүү өртөж байгааг үнэлэх зорилгоор сэтгэл санаа, бие махбод, бэлгийн, эдийн засаг болон үл хайхрах зэрэг хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзвэл Бие махбодын 161 (16.7%), Сэтгэл санааны 295 (30.7%), Бэлгийн 26 (2.7%), Үл хайхрах 255 (26.5%), Эдийн засгийн 268 (27.9%) өртжээ. Үүнээс харахад аль ч хүчирхийллийн үед сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртдөг байна. (Зураг 2)




Зураг 2. Судалгаанд хамрагдагсдын хүчирхийллийн хэлбэрүүдийг судалсан дүн

Хүчирхийлэл үйлдсэн үйлдэл нь 73 (45.3%) өшиглөх, 86 (50.0%) алагдах, 107(66.4%), цохих, 36 (22.4%) чимхэх, 80 (50.0%), 50.0% түлхэх, 7 (4.4%) хазах, 81 (50.3%), эд зүйл шидэх үйлдэл нь статистик ач холбогдолтой байна ($p<0.05$). Үүнээс зэвсгийн чанартай эд зүйл тодруулахад хутга, мэс 15 (15.4%), мод чулуу 53 (11.9%), бусад шил сандал 29 (14.2%) ашигласан статистикийн хувьд ач холбогдолтой байв ($p<0.05$). (Зураг 3)




Зураг 3. Судалгаанд хамрагдагсдын Бие махбодын хүчирхийллийн үйлдлийг судалсан дүн.

Сэтгэл санааны хүчирхийллийн үйлдэл нь муу үгээр хараах 215 (22.3%), Загнах 224 (23.3%), буруутгах 160 (16.6%), айлгах 108 (11.2%), хардаж мөрдөх 33 (3.4%), сүрдүүлэх 84 (8.7%), сонирхол харгалзахгүй шийдвэр 67 (7.7%), ганцаардуулах 184 (19.1%), шийтгэнэ гэж сүрдүүлэх 64 (6.7%) статистик ач холбогдолтой байна (p=0.000). (Зураг 4)




Зураг 4. Судалгаанд хамрагдагсдын сэтгэл санааны хүчирхийллийн үйлдлийг судалсан дүн.

Үл хайхрах хүчирхийллийн үйлдэл нь 190 (18.9%) гадуурхах, 190 (18.9%) ярихгүй байх,107(11.3%) хэрэгцээ хангагдахгүй, 173 (18.8%) асаргаа хийгдэхгүй, 55 (5.7%) гэрээс хөөх, 36 (3.7%) эм уулгахгүй, 78 (8.1%) ад шоо үздэг байна (p=0.000). (Зураг 5)



Зураг 5. Судалгаанд хамрагдагсдын үл хайхрах хүчирхийллийн үйлдлийг судалсан дүн.

Эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн үйлдэл нь эд хөрөнгө завших 73 (7.6%), мөнгө хулгайлах 110 (11.4%), зээл зөвшөөрөлгүй авхуулах 132 (13.7%), тэтгэвэр өгөхгүй байх 101 (10.5%), өөрийн хэрэгцээнд зарцуулахгүй 174 (18.1%), орон байр зөвшөөрөлгүй зарах 31 (3.2%), данснаас мөнгө зөвшөөрөлгүй авах 76 (7.9%), бичиг баримтад гарын үсэг зуруулах 33 (3.4%), ахуйн хэрэгцээ хангагдахгүй байх 67 (7.0%), эрүүл мэндийн хэрэгцээ хангагдахгүй 165 (17.1%), байх зэрэг хүчирхийлэх үйлдэл нь статистик ач холбогдолтой байна (p<0.05). (Зураг 6)



Зураг 6. Судалгаанд хамрагдагсдын эдийн засгийн хүчирхийллийн үйлдлийг судалсан дүн.

Хэлцэмж: Ахмад настны хүчирхийлэл тархалт олон улсад 2.2-36.2% буюу дундаж 14.3% байна. Улс тус бүрээр авч үзвэл Хятад 36.2%, Нигери 30.0%, Израил 18.4%, Мексик 10.3%, АНУ 9.5%, Канад 4.0%-тай байгаа бөгөөд нас ахих тусмаа хувийн асуудлаа нуух хандлагатай болдог гэжээ. Судлаач Coren (2008) нар хүчирхийлэл нь 3,2-27,8% тархалттай, биеийн 1,9%, ЭЗ 4,1%, 3,6% үгэн хүчирхийлэл, 2,4% үл хайхрах, 4,2% Сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн байна.[6] Судалгаанд сэтгэл санааны хүчирхийлэл хамгийн их 40,1% настны дунд тодорхойлогддог бол бие махбодын 31,3% эдийн засгийн 7,2% үл хайхрах 19,1% бэлгийн 1,3% үл хайхрах 1%. Дэлхий дахинд хүчирхийллийн үзүүлэлт сэтгэл санаа-11,6%, эдийн засаг-6,8%, үл хайхрах 4,2%, биеийн хүчирхийлэл 2,5%, бэлгийн хүчирхийлэл-0,9% тодорхойлогддог. Гэтэл бидний судалгаанд хамрагдагсдын 50.7% нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн байгаа нь дээрх улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Судлаач Ven Den (2019) нар сэтгэл санааны хүчирхийлэл 44,5%, эдийн засгийн 34% бие махбод 19.1%, бэлгийн хүчирхийлэл хамгийн бага 3% эзэлсэн гэжээ.[7] Бидний судалгааны хүчирхийллийн хэлбэрүүдийн үр дүнг Судлаач Ven Den (2019) нарын судалгааны үр дүнтэй ойролцоо байлаа.

Дүгнэлт: Ахмад настны олонх нь сэтгэл санааны, эдийн засгийн, үл хайхрах бие махбодын, хавсарсан хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг байна. Үүнээс харахад аль ч хүчирхийллийн үед сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртдөг байна. хүчирхийллийг тэдний ойр дотны гэр бүлийн гишүүд, үйлдэж байна. Хүчирхийлэл нь цохих, алгадах, буруутгах, муу үгээр хэлэх, эмзэг эрхтэнд хүрэх, ярихгүй байх, ганцаардуулах, эдийн засгийн болон эрүүл мэндийн хэрэгцээ хангагдахгүй байх зэрэг үйлдлүүд давамгайлж байна.

Ном зүй:

1. *World health Organization. Elder abuse 2018 ttp//www.who.int/ medicantre/factsheets/fs357/en*
2. *Xinqi Dong. "States Elder Abuse in Chinese Populations: A Global Review" Journal ofElder Abuse & Neglect, 27:196–232, 2015 on DOI: 10.1080/08946566.2015.1039154*
3. *Р.Оюунханд. Монгол улсын настнуудын өвчлөлийн тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндийн байдал 2011он.х.3*
4. *Н. Оюунгоо. Ахмад настны сэтгэл зүйн асуудлууд. УБ 2018 он.х. 7*
5. *Ц.Дулмаа, М.Сугирмаа Асран хамгаалагчдын нийгэм- сэтгэл зүйн зарим асуудал. Нийгмийн ажил.УБ 2013 18-21*
6. *Cooper C, Selwood A, Livingston G. The prevalence of elder abuse and neglect: a systematic review. Age Ageing. 2008;37(2):151-160.*
7. *Van Den Bruele AB, Dimachk M, Crandall M. Elder Abuse. Clin Geriatr Med. 2019;35(1):103-113.*
8. *World Health Organization Updated October 2015 http;// w.w.w.who.int/ medicine/ factsheets/fs 357/en/*
9. *World Health Organization Updated January 2018 http;// w.w.w.who.int/ medicine / factsheets/fs 357/en/*
10. *Р.Оюунханд, Ж.Мөнхцэцэг, Н.Занди, Г.Алтанзул Улаанбаатар 2010 он. х. 9*
11. *Ахмад настны тухай хууль 2017 он 1-р сарын 26 шинэчлэн найруулсан. 3-р дугаар зүйл (3:1) httpl;// Legalinfo.mn/ Law/ show Print/ 12353*
12. *World Health Organization 2015 http;// w.w.w.who.int/violence – Jngury- prevention/ violence/en/*
13. *Global status report on violence prevention. Geneva. World Health Organization. 2014 Switzerland; WHO. Press*
14. *Wallace, R.B.Bonnie.R.J. Elder mistreatment, abuse, neglect and exploitation imaging America. Washingtion DC; National Academies press. 2013*
15. *Global status report on violence prevention 2014. World Health Organization 2014. Geneva. Switzzerland WHO.press*
16. *The social context of abuse of elderly people in Emuhaya District, Kenya.Sociology and Antroplogy Kabole. A.L. Kioli.F.N.2013,1,76-86, dio; 10.13189/ Sa.2013.010206.*
17. *Financial Abuse of older people by Family . Journal Elder abuse 2013 http;// w.w.w tgndfonline .com/ loi/ wean.20.*
18. *Монгол улсын статистикийн хороо, НҮБ- ын Хүн амын сан болон Швейцарийн Хөгжлийн Агентлагийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр хийгдсэн "Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан" 2018 он*
19. *World Health Organization 2018 Elder abuse. https://www.who.int/news-room/fact-sheets/detail/abuse-of-older-people*
20. *Xinqi Dong. "States Elder Abuse in Chinese Populations: A Global Review" Journal ofElder Abuse & Neglect, 27:196–232, 2015 on DOI: 10.1080/08946566.2015.1039154*
21. *Elder abuse. American psychological association. www.ara.org/ pi/aging. 2012 on Cooper, Claudia, and Gill Livingston. "Mental Health/Psychiatric Issues in Elder Abuse and Neglect." Clinics in Geriatric Medicine, vol. 30, no. 4, 2014, pp. 839–850., doi:10.1016/j.cger.2014.08.011.*
22. *Daly, Jeanette M., and Howard K. Butcher. "Evidence-Based Practice Guideline: Elder Abuse Prevention." Journal of Gerontological Nursing, vol. 44, no. 7, Jan. 2018, pp. 21–30., doi:10.3928/00989134-20180614-05.*
23. *Dong, XinQi. Elder Abuse Research, Practice and Policy. Springer International Publishing, 2018.*
24. *Evans, Christopher S., et al. "Diagnosis of Elder Abuse in U.S. Emergency Departments." Journal of the American Geriatrics Society, vol. 65, no. 1, 2016, pp. 91–97., doi:10.1111/jgs.14480.*
25. *Yunus, Raudah Mohd, et al. "Consequences of Elder Abuse and Neglect: A Systematic Review of Observational Studies." Trauma, Violence, & Abuse, vol. 20, no. 2, 2017, pp. 197–213., doi:10.1177/1524838017692798.*
26. *Dong, X., & Simon, M. (2010a). Gender variations in the levels of*

social support and risk of elder mistreatment in a Chinese community population. Journal of Applied Gerontology, 29(6), 720–739.

27. *Dong, X., & Simon, M. (2010b). Is impairment In physical functIon assocIated wIth increased rIsk of elder mistreatment? Findings from a community-dwelling Chinese population. Public Health Reports, 125.*
28. *Dong, X. (2014a). Do the definitions of elder mistreatment subtypes matter? Findings from the PINE Study. J Gerontol A Biol Sci Med Sci, 69 Suppl 2, S68–75.*
29. *Dong, X. (2014b). Self-neglect in an elderly community-dwelling U.S. Chinese population: Findings from the population study of Chinese elderly in Chicago study. J Am Geriatr Soc, 62(12), 2391–2397. doi:10.1111/jgs.13140*

Forms and acts of violence against the elderly in Ulaanbaatar

Dolgorsuren D[1,2], Batchimeg P[1], Myagmartseren D[2], Khishigsuren Z[2]

[1]Department of Mental Health, School of Medicine, MNUMS
[1]Department of Family Health, School of Medicine, MNUMS
[2]Dornogovi Medical School, MNUMS
E-mail: dolgorsuren.d@mnums.edu.mn, Tel: +976-99022964

Background: According to the World Health Organization's 2018 report, there are 900 million people aged 60 and over in the world in 2015, and it is estimated that it will increase by 2 times in 2050. 1 Researchers have determined that elder abuse is common among the Chinese population, or 0.2%-64%. 2 In Mongolia, researchers R. Oyunkhand et al. showed that personality disorders, anxiety, and depression are the most likely to be related to elder abuse. It is mentioned that it is necessary to study.

Aim: The result of studying the forms and acts of violence against the elderly in Ulaanbaatar.

Materials and Methods: The research was conducted using a one-moment design, and the data was collected by combining quantitative and qualitative research methods using targeted sampling.

Results: A total of 962 elderly people aged 55-96 participated in our study, the average age was 65.6±7.49 years, and the average family size was 3.33±1.96. 161 (16.7%) of the elderly victims of physical abuse, 295 (30.7%) emotional, 26 (2.7%) sexual abuse, 255 (26.5%) neglect, and 268 (27.9%) economic abuse. From this it can be seen that in any violence, there is a double exposure to emotional violence. Physical violence was kicking 72 (10.0%), killing 86 (8.6%), hitting 107 (6.3%), pinching 22.4% 36 (13.5%), pushing 80 (9.2%), biting, throwing objects 81 (9.1%), the action is statistically significant ($p<0.05$). Of these, 15 (15.4%) knives and scissors, 53 (11.9%) wood and stone, and 29 (14.2%) other glass and chairs were statistically significant ($p<0.05$). The emotional violence acts include cursing with bad words 215 (22.3%), scolding 224 (23.3%), blaming 160 (16.6%), intimidating 108 (11.2%), stalking 33 (3.4%), threatening 84 (8.7%), 67 (7.7) decided not to take into account interests, 184 (19.1) decided to isolate, and 184 (19.1) decided to punish and put them in care 64(6.7%) acts of intimidation are statistically significant ($p=0.000$). Neglectful acts of violence were 190 (18.9%) exclusion, 190 (18.9%) not talking, 107 (11.3%) not having needs met, 173 (18.8%) not being cared for, 55 (5.7%) eviction, 36 (3.7%) drugs. do not drink, 78 (8.1%) watch gambling ($p=0.000$). Economic violence was embezzlement 73 (7.6%), stealing money 110 (11.4%), taking loans without permission 132 (137%), not paying pension 101 (10.5%), not spending for personal needs 174 (18.1%), selling housing without permission 31 (3.2), withdrawing money from accounts without permission 76 (7.9), signing documents 33(3.4%), unmet household needs 67 (7.0%), unmet medical needs 165171.2%, violent acts were statistically significant ($p<0.05$).

Conclusion: Considering the form of violence, 161 physical (16.7%), emotional 295 (30.7%), sexual 26 (2.7%), neglect 255 (26.5%), economic 268 (27.9%) were subjected to any form of violence. It has been determined that they are subjected to emotional violence.

Keywords: Elderly, Violence, Form, Action